

**ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БОЛОН
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Төсөв	Хүрсэн түвшин /хэрэгжүүлсэн арга хэмжээ/	Хувь
1	2	3	4	5	6	7
Нэг. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд :						
1.1.1. Аймгийн Засаг даргаас Төсвийн шууд захирагч нартай байгуулах гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах чиглэлээр заалт тусган, үр дүнг тооцох.	Гэрээнд тусгасан заалтын тоо	2	2	-	Гэрээний хөтөлбөр 6-д авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх байгууллагын шударга байдлын үнэлгээг дээшлүүлэх зeaалтуудыг хэрэгжүүлэн ажилласан . Төлөвлөгөө тусган сумын Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хурлаар батлуулж үр дүнг тооцон ажилласан. Авлига ашиг сонирхолын зөрчлөөр иргэдээс өргөдөл гомдол гаргаагүй. Аймгийн Засаг даргатай сумын Засаг дарга байгуулсан хамтран ажиллах гэрээнд заасны дагуу үр дүнг тооцож төрийн байгууллага албан хаагчид, иргэд олон нийтэд ашиг сонирхлын зөрчлөөс урдчилан сэргийлэх чиглэлээр сургалт сурталчилгээ 2 удаа явуулж иргэд олон нийтийг мэдээллээр ханган ажилласан.	100

<p>1.1.2. Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн чиглэлээр Сумдын Засаг даргын Тамгын газар, 21 агентлаг, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой ААН байгууллагын удирдах албан тушаалтнуудыг арга зүйгээр хангаж, нийт мэдүүлэг гаргагч нарын 2022 оны шинэчлэн гаргах хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулж, холбогдох мэдээг тайланг АТГ-т хүргүүлэх.</p>	<p>Мэдээлэл оруулсан төрийн албан хаагчдын тоо</p>	<p>9</p>	<p>9</p>	<p>-</p>	<p>2023 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг төрийн захиргааны болон байгууллагын удирдах ажилтан 9 хүний мэдүүлгийг хуулийн хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад тайлан мэдээг хүргүүлсэн. Мөн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ЭБАТ 14 хүний хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргаж мэдээ тайланг хүргүүлсэн.</p>	<p>100</p>
<p>1.2.2. АТГ-аас зохион байгуулдаг анхан болон давтан сургалтанд албан хаагчдаа хамруулах</p>	<p>Сургалтанд хамрагдах албан хаагчдын тоо</p>				<p>Энэ онд авлигын эсрэг сургалтанд 2 төрийн албан хаагч цахимаар хамрагдаж мөн төрийн албан хаагчдад 2 удаа цахимаар сургалт хамрагдсан. авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан цахим сургалтанд Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын дарга, Тамгын газрын дарга нар хамрагдсан.</p>	<p>100</p>

<p>1.2.3. Авлигын эсрэг сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан, иргэд хүүхэд залуучуудад хүргэх үйл ажиллагааг АТГ болон аймгийн БСУГ-тай хамтран шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүнг тооцож, тайлагнах.</p>	<p>Сургалтын тоо</p>	<p>2</p>	<p>2</p>		<p>Иргэдийн сэтгэхүй, сэтгэлгээ хандлагад өөрчлөлт оруулах зорилгоор иргэдэд сургалт сурталчилгааг мэдээллийн самбар болон цахим хуудсаар хийж ажилласан. Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэрээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган сумын цахим сайт болон байгууллагын сайтад байршуулсан.</p> <p>Авлигын эсрэг сургалт сурталчилгааг цахимаар зохион байгуулж сумын вэйб сайт болон мэдээллийн самбарт боршур, гарын авлага хийн байршуулж, иргэд хүүхэд залуучуудад тараан сурталчилсан. Засаг даргын Тамгын газарт мэдээллийн самбарыг 2, албан байгууллагууд 4, иргэдээс мэдээлэл авах суурин утас 3-ыг тогтмол ажиллуулж байна.</p>	<p>70</p>
<p>1.3.1. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, түүнтэй тэмцэх үйл ажиллагаанд тодорхой төсөв, хөрөнгө төлөвлөн зарцуулах.</p>	<p>Сургалтын тоо</p>	<p>2</p>	<p>2</p>	<p>500,0</p>	<p>Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засаг даргаар батлуулан албан байгууллага, аж ахуйн нэгж, сумын иргэд, авлигын эсрэг хууль тогтоомж бусад эрх зүйн актуудыг суртачилан таниулж мэдээллийн самбар болон сумын вэб сайтад ил тод нээлттэйгээр мэдээлэл хийсэн. Багийн Засаг дарга нартай хамтран ажилласан. 2023 оны төсөвт 500,0 төгрөг төлөвлөн мэдээллийн самбар тараах материал, сургалтанд зарцуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p>	<p>100</p>

<p>1.3.3. Төрийн байгууллага хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах.</p>	<p>Гэрээнд зааснаар</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>Хууль, эрх зүйн мэргэжилтэний гүйцэтгэлийн төлөвлөгөөнд МУ-ын хууль, УИХ-ын тогтоол, ЗГ-ын тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, шийдвэрийг хэрэгжүүлэх, авлигын эсрэг соён гэгээрүүлэх сургалт сурталчилгаа зохион байгуулах, иргэдэд мэдээллэх, ИТХ, багийн Засаг дарга нартай хамтран уулзалт, ярилцлага зохион байгуулах талаар тусгаж хэрэгжүүлсэн. Ажил гүйцэтгэх гэрээ болон бусад гэрээний заалтанд авлига ашиг сонирхолын зөрчлөөс ангид байх талаар заалт оруулан ажиллаж байна. Авлигын эсрэг төлөвлөгөөг оны эхэнд боловсруулан Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор батлуулан иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргатай хамтран биелэлт үр дүнг тооцон ажиллаж байна.</p>	<p>70</p>
<p>Хэрэгжилтийн хувь. 90%</p>						
<p>Хоёр. Сум, агентлагийн /байгууллагын/ авлигын төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд:</p>						
<p>2.1.1. Үйл ажиллагаандаа ашиглаж буй аймгийн албан ёсны цахим хуудас www.uvurkhangai.mn сайтад, хэлэлцэгдэж буй хууль, шийдвэрийн төслийг байршуулж, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд олон нийтийн зүгээс санал, хүсэлт илэрхийлэх бололцоог бүрдүүлэх.</p>	<p>Хандалтын хувь</p>	<p>40%</p>	<p>80%</p>	<p>280,0</p>	<p>Төрийн захиргааны албан хаагчид ажил үүргийн талаарх мэдээл болон шилэн данс, ОНХС-ын үйл ажиллагаа, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтуудыг өөрсдийн цахим хуудас болон сумын zuunbayan-ulaan.ov.gov.mn вэйб сайтад байршуулж байна. Мөн гарсан Засаг даргын захирамж, Тамгын газрын даргын тушаал, бусад шийдвэр, төлөвлөгөө тайланг байршуулан ажиллаж байна. Авлигын эсрэг төлөвлөгөө, соён гэгээрүүлэх төлөвлөгөө, авлигад өртөд болзошгүй албан хаагчдын жагсаалт, АТҮХ зэрэг тайлан мэдээг байршуулан ажиллаж байна. Сумын Засаг даргын захирамжийг аймгийн хууль зүйн хэлтэст хагас жилийн байдлаар хянуулхаар хүргүүлсэн. Сумын албан ёсны zuunbayan-ulaan.ov.gov.mn сайтыг жил бүр 280,0 төгрөгөөр сэргээн үйл ажиллагаа явуулж байна.</p>	<p>70</p>

<p>2.1.2. Иргэд олон нийт, санал, хүсэлт илэрхийлэх бүлгүүдтэй санал солилцож, гаргасан санал хүсэлтийг хүлээн авах.</p>	<p>Санал хүсэлтийн тоогоор</p>	<p>0</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах суурийн утас 3-ыг Засаг даргын Тамгын газарт-1, ЭТМ-1, ЕБС-1 утас тус тус ажиллуулж сумын албан ёсны пэйж цахим хуудсаар санал гомдол авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Иргэдээс цахимаар, цаасаар санал гомдол ирээгүй.</p>	<p>100</p>
<p>2.2.4. Байгууллагын цахим хуудсанд авлигын эсрэг үйл ажиллагааны урд оны тайлан, 2022 оны төлөвлөгөө, иргэд болон хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудад зориулсан шаардлагатай гарын авлага, тараах материал бусад мэдээллийг бэлтгэн байршуулж, тогтмол шинэчлэх.</p>	<p>Тухай бүр</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>Байгууллагын цахим хуудсанд авлигын эсрэг үйл ажиллагаа, төлөвлөгөө тайланг тогтмол гарган байршуулж мэдээллийг цаг тухай бүр шинэчлэн гаргаж тогтмолжсон. Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах 9 албан тушаалтанд 1 удаагийн сургалт зөвлөгөө мэдээллийг өгч мөн ИТХ-ын төлөөлөгч 21 хүнд 1 удаа сургалт зохион байгуулж гарын авлагаар хангасан.</p>	<p>100</p>
<p>2.3. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3. Төрийн хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах.</p>	<p>Тухай бүр</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>Байгууллага бүрт дотоод хяналтын баг ажилладаг бөгөөд улсын төсвийн хөрөнгө оруулалт, орон нийтийн хөгжлийн сангаар хийгдэх ажил зэрэгт ажлын хэсэг гаргаж ажилладаг ба ажлын хэсэгт иргэний төлөөлөл болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдээс оролцуулан ажлын явцад хяналт шалгалт хийж иргэдэд нээлттэйгээр мэдээллэсэн. Тус сумын өртөнт нарийн жалгын алтны уурхайн нөхөн сэргээлтийн явцад хэсгийн төлөөлөгч, байгаль орны асуудал хариуцсан мэргэжилтэн нарийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 3 удаа хяналт шалгалт хийсэн.</p>	<p>70</p>

<p>2.4.1. Тухайн жилийн төсвийг 1 дүгээр сарын 10-ны дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг 4 дүгээр сарын 1-ний дотор, дараа жилийн төсвийн төслийг 8 дугаар сарын 15-ны дотор, жилийн эцсийн санхүүгийн тайлан болон санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 5 дугаар сарын 1-ний дотор, төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг өөрчлөлт орсон өдрөөс хойш 14 хоногийн дотор тус тус цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулах.</p>	Тухайн хугацаанд	-	-	-	Тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийг 12 дугаар сарын 20-нд өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг 4 дүгээр сарын 1-ээс өмнө аудитаар оруулж баталгаажуулан шилэн дансанд болон сумын сайтад байршуулж байна. Мөн байгууллагын ил тодын самбарт байршуулан ажиллаж байна. Төсөвт орсон өөрчлөлт байхгүй.	100
<p>2.4.2. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүх)</p>	Тухай бүр	-	-	-	цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг байгууллага бүрээр болон сумын нэгдсэн дүнгээр сар бүр тухай бүр оруулах мэдээлэлд оруулж байна.	100
<p>2.4.3. Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох. (татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл) Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарын хамт мэдээлэх.</p>	Тухай бүр	-	-	-	Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр мэдээллийн самбарт байршуулж, шилэн дансанд холбогдох мэдээллүүдийг хуулийн хугацаанд байршуулж байна. Орон нутгийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх зорилгоор оны эхэнд батлагдсан орлогын төлөвлөгөөний хуваарийг гарган татвар төлөгч нэхэмжлэл хүргүүлж, хуваарийн дагуу орлогыг оруулж, хяналт тавин ажиллаж байна. Орон нутгийн төсвийн төслийг боловсруулан олон нийтэд мэдээлэн, саналыг тусгаж холбогдох газарт хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллаж байна.	100

<p>2.6.1. (Аймгийн Засаг даргын захирамжийн нууцад хамааруулснаас бусад) болон бусад төрийн байгууллага удирдлагаас гаргасан шийдвэрийг байгууллагын цахим хуудаст байршуулж, нийтэд ил тод мэдээлэх.</p>	<p>Тухай бүр</p>				<p>Байгууллагуудын орон тоо бүтцийн өөрчлөлт оруулан аймгийн Засаг даргын захирамжийг иргэдэд ил тод мэдээллэж байна. Өөрчлөлт орсон албан тушаалтан өөр ажилд шилжсэн, халагдсан, тэтгэвэрт гарсан тохиолдол бүрт ажлын байрны сул орон тоог зарлаж, иргэдэд мэдээллийн самбар болон цахимаар мэдээллэж ажиллаж байна. Мөн төсвийн байгууллагуудаас гарч буй нийтэд хамаарах шийдвэрийг цахим болон ил тодын самбараар дамжуулан танилцуулж байна.</p>	<p>70</p>
<p>2.6.2. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж (хуульчилсан акт) дүрэм, журам, заавар болон төлбөрт үйлчилгээний жагсаалтыг цахим хуудсандаа байршуулах.</p>	<p>Хууль журмын тоогоор</p>	<p>2</p>	<p>2</p>		<p>Албан хаагч бүр үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль дүрэм журмыг мэдээллийн самбар болон сумын цахим хуудас мөн өөрсдийн цахим хуудсаар олон нийтэд мэдээллэн сурталчилж байна. Нотариатын хууль тогтоомжийн дагуу иргэдэд 4 төрлийн үйлчилгээг үзүүлж, тогтоосон тарифын дагуу төлбөр хураамжийг авч бүтэн жилээр тайланг хууль зүйн хэлтэст хүргүүлсэн. Иргэний цахим үнэмлэх, нийгмийн даатгалын шимтгэл, эрүүгийн хэрэгт холбогдсон эсэх лавлагаануудаар иргэдэд үйлчилгээ үзүүлсэн. Заавар журам тарифыг ил тодын самбарт байрлуулан мэдээлэл өгч байна.</p>	<p>70</p>
<p>2.7.1. Иргэдийн өргөдөл (санал, мэдэгдэл), гомдол, хүсэлт, мэдээлэл өóóðàé хүлээн авах нөхцөлийг бүрдүүлүө, (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр), шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын мэдээлийг талаарх мэдээлэл</p>	<p>Санал хүсэлтийн тоогоор</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>Иргэдийн гомдол мэдээллийг бичгээр, утсаар болон санал хүсэлтийн хайрцаг, цахимаар дамжуулан хүлээн авч байна. Мэдээлэл хүлээн авах суурийн утас-3, санал хүсэлтийн хайрцаг 1-г байршуулсан. Иргэдээс нийт 326 өргөдөл ирснээс 317 өргөдөлийг шийдвэрлэж, 9 өргөдөл хүлээгдэж байна.</p>	<p>100</p>

<p>2.7.2. Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийн хүлээн авч уулзах цагийн хуваарийг ил тод мэдээлэх.</p>	Тухай бүр	-	-	-	<p>Ажилтан бүрийн утасны дугаарыг мэдээллийг самбарт ил тодоор байршуулсан. Өргөдөл гомдол хариуцсан ажилтны талаарх мэдээллийг ил тод самбарт байршуулж сумын Засаг дарга, ИТХ-ын дарга нар иргэдийг хүлээж авах цагийн хуваарийг гарган мөрдөн ажиллаж байна. Мөн Засаг даргын Тамгын газрын ажилтан албан хаагчдын утасны дугаарын жагсаалтыг гаргаж байршуулсан.</p>	100
<p>Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх.</p>	Журмын дагуу	-	-	-	<p>Төрийн албаны тухай хууль болон бусад журмын дагуу ерөнхий болон тусгай шалгалт өгч тэнцэн нөөцөд бүртгэгдсэн иргэдийг сул орон тоонд авч ажиллуулж байна. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ёс зүйн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх чиглэлээр тусгайлан заалт оруулж үр дүнг тооцон ажиллаж байна.</p>	100
<p>3.1.5. Сул орон тооны зар болон байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлийг сар бүр цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан, ил тод байдлыг хангаж ажиллах.</p>	Сул орон тоог оор	1	1	-	<p>Засаг даргын Тамгын газар нь бэлчээр газар тариалан харицсан мэргэжилтний сул орон тоог аймгийн төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж цахим болон мэдээллийн самбарт ил тодоор байршуулсан. Төрийн албаны шалгалтанд тэнцсэн 1 иргэнийг ажиллуулж ажлын байрны сул орон тоо байхгүй ажиллаж байна.</p>	100

<p>.2.2. Сургалтын модуль, давтан сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх.</p>					<p>Төрийн албан хаагчдын сургалт-хөгжил аймгийн дэд хөтөлбөрийг жил бүр хэрэгжүүлэх сумын төлөвлөгөөг төлөвлөж Засаг даргаар батлуулан биелэлтийг тооцон ажиллаж байна. Сургалттай холбогдуулан төрийн албан хаагчдын цаашид сургалтанд хамрагдах, дахин сурах, мэргэшүүлэх хэрэгцээг тодорхойлох судалгааг албан хаагчдаас авч сургалтын хэрэгцээг тогтоох судалгааны дүнг нэгтгэн гаргаж холбогдох сургалтуудад сургаж хэвшсэн.</p> <p>Төрийн албаны зөвлөлөөс пүрэв гариг бүрийн модул сургалтанд байгууллагын дарга эрхлэгч, Засаг даргын Тамгын газрын албан хаагч тогтмол хамрагдаж байна. ЗДТГ-ын ажилтан албан хаагчид өөрсдийн эрхэлсэн ажлын хүрээнд холбогдох байгууллагаас зохион байгуулж буй цахим болон танхимын сургалтанд бүрэн хамрагдсан. Засаг даргын тамгын газрын ажилтан албан хаагчид 52 удаа цахим, 18 удаа танхимын сургалтанд хамрагдсан байна.</p>	<p>100</p>
<p>3.3.1. Ёс зүйн дүрмийг ил тод байршуулах.</p>	<p>Тухай бүр</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>ЗДТГ нь байгууллагынхаа ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулж, байгууллагынхаа хурлаар батлан мөрдөн ажиллаж, мэдээллийн самбарт ил тод байршуулан ажиллаж байна. Мөн өрөө тасалгаа бүр төрийн болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг байрлуулсан. Ёс зүйн хариуцлага алдсан төрийн албан хаагч байхгүй. Ёс зүйн мэдээг хагас жилээр гаргаж аймгийн төрийн захиргаа удирдлагын хэлтэс хүргүүлсэн. Ёс зүйн дүрмийг шинээр ажилд орсон төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад танилцуулж гарын үсэг зуруулсан.</p>	<p>100</p>

3.3.2. Төрийн байгууллагын ёс зүйн хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэх.	Сургалтын тоогоор	2	2	-	Тус сумын бүх албан байгууллагууд ёс зүйн зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулж жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. Албан байгууллага бүрийн ёс зүйн зөвлөлөөс албан байгууллагынхаа албан хаагчдад төрийн албан хаагчдын ёс зүй, манлайллын чиглэлээр сургалт зохион байгуулж ажилласан бөгөөд ЗДТГ-ын ёс зүйн зөвлөлөөс тараах материал, брошур бэлтгэн сурталчилгаа хийв.	100
--	-------------------	---	---	---	---	-----

<p>3.4.1.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах.</p>	<p>Лавлагааны тоогоор</p>				<p>Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт үе шаттайгаар шилжүүлэн иргэдэд түргэн шуурхай үйлчлэх боломжийг бүрдүүлж байна. Хур цахим үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор Саммот компьютер технологи ХХК-аас тоон гарын үсэг ашиглаж 275 нэр төрлийн бүртгэлийг иргэдэд үзүүлж лавлагаа мэдээлэл өгч байна. Мөн төрөөс үзүүлэх үйлчилгээг хялбаршуулах, иргэдэд ойртуулах зорилгоор etax.mn сайтаар дамжуулан татвар төлөгч нар татварын тайлангаа илгээх, татвараа төлөх зэрэг үйлчилгээг, ndaatgal.ov.gov.mn сайтаар дамжуулан нийгмийн даатгалтай холбоотой зөвлөгөө, мэдээллийг мөн esafe халамжийн системээр дамжуулан жирэмсэн эхийн тэтгэмж, 0-3 хүртэлх хүүхэд асарсны тэтгэмж, ихэр хүүхдийн тэтгэмж, 0-18 насны 3 болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж, насны хишиг зэрэг үйлчилгээг авч байна. Дээрх үйлчилгээний талаар иргэдэд сурталчилж байна. Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах үүднээс цахимаар хурууны хээ авч бүртгэлжүүлэх таблет, хурууны хээ уншигчаар хангасан. Улсын бүртгэгчээс иргэдэд 10 төрлийн бүртгэл, харъяалал харгалзахгүй 3 төрлийн бүртгэл, харъяалал харгалздаг 3 төрлийн бүртгэл мөн цахимаар 13 төрлийн лавлагааг олгож байна. Улсын бүртгэгч 1448 иргэний тоон гарын үсгийг баталгаажуулсан байна.</p>	<p>70</p>
<p>3.7.1. Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээллэх ажлыг зохион байгуулах. (бүтэн жилээр,сар бүр)</p>	<p>Тухай бүр</p>	<p>-</p>	<p>-</p>		<p>Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөг хагас бүтэн жилээр, гүйцэтгэлийг сар бүр шилэн дансанд байршуулж байна. Мөн ЗГУМС-д багуудаас ирсэн санал, багийн ИНХ-ын тогтоол болон ажлын хэсгийн эрэмбэлэлт, ИТХ-ын тогтоол, ОНХсангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг оруулж байна.</p>	<p>100</p>

3.7.2. Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг бүтэн жилээр болон сар бүр байршуулж мэдээлэх.	Тухай бүр	-	-	-	ОНХ сан, сум хөгжүүлэх сангийн төлөвлөгөө гүйцэтгэлийг тухай бүр нь шилэн дансанд байршуулж байна.	100
3.7.3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр шивж мэдээлсэн байх.	Тухай бүр	-	-	-	2023 онд цахимаар зарласан тендрүүдийн үнэлгээний хорооны гишүүдээр ашиг сонирхлын зөрчилгүй гэсэн мэдүүлэг байнга бөглүүлж байна. Мөн шинээр ажилд орсон хүмүүсийн тушаалуудыг тухай бүр нь шилэн дансанд байршуулж байна. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын мэдэгдэл тайлбарыг төрийн албан хаагчдаас авч авлигатай тэмцэх газрын сайтад шивж мэдээллэсэн.	100
3.8.1. Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах.	Хуулийн хугацаанд	-	-	-	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын саналыг урд онуудад нь иргэдээс санал авч эрэмбэлэн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж байна. .	100
3.8.2. Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын www.iltod.mn, www.shilendans.com цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх.	Тухай бүр	-	-	-	Төсвийн төсөл болон иргэдийн саналыг сумын вэб сайтад жил бүр мэдээлж байна. Мөн сумын төсвийн төслийн нэгтгэлийг бүтэн жилээр гарган шилэн дансанд байршуулж хэвшсэн.	100
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байршуулах	Тухай бүр	-	-	-	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 1 дүгээр сарын 10-ны дотор шилэн данс байршуулж tender.gov.mn сайт болон сумын вэб сайтад байршуулсан.	100
Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайланг байршуулах (хагас, бүтэн жил)	Тухай бүр	-	-	-	Худалдан авах ажиллагааны тайланг хагас бүтэн жилээр ХОХБХ-т маягтын дагуу явуулж байна. Мөн шилэн данс болон ОНХсангийн ЗГУМС-д тайланг шивж оруулж байна.	100

3.11.1.Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлж, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэх.	Тухай бүр	-	-	-	Төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зардлыг шилэн дансанд тухай бүр тогтмол тавьж мэдээллийн самбарт ил тодоор байршуулан ажиллаж байна. Орон нутгийн сангийн үйл ажиллагаанд .	70
Хэрэгжилтийн хувь: 93%						
Нийт хувь: 91.5%						

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Б.ШАГДАРСҮРЭН

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ

Н.ДАВААСҮРЭН

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГА

Б.БААСАН

Хүснэгт -2

д/д	Төлөвлөгөөний хүрээнд	Хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг
-----	-----------------------	---------------------------------

	гүйцэтгэсэн ажлын төрөл	тоо баримтаар товч дурьдах
1	Сум, байгууллагын албан ёсны ямар вэб сайтад авлигын эсрэг хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, мэдээ, мэдээлэл, жилийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг байршуулсан талаар /цахим хуудасны нэр, хаяг, аль хэсгээс харах/	Zuunbayan-ulaan.ov.gov. mn сайтын Ил тод цэсний авлига гэсэн хуудсанд байршуулсан байгаа.
2	Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гаргасан шийдвэр /тоо/	
3	Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгө	500,000+280,000
4	Зохион байгуулсан цахим болон танхим сургалтын тоо	Танхимаар 2 удаа сургалт зохион байгуулсан.
5	Цахим болон танхимын сургалтанд хамрагдсан удирдах албан тушаалтан, төрийн албан хаагч, иргэдийн тоо	1.удирдах албан тушаалтны тоо 9 2.төрийн албан хаагчийн тоо 46 3. иргэдийн тоо.116 Нийт тоо 171
6	Авлигын хууль тогтоомжийн чиглэлээр тараасан гарын авлага, тараах материалын тоо	810
7	Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулага, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг материал г.м/	Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар нээлттэй хаалганы өдрийг 10 сард зохион байгуулж шторк, видео бичлэг, гарын авлага, брошур хийж тараасан.
8	АТҮхөтөлбөр болон Авлигын эсрэг үйл ажиллагаан жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарсан өөрчлөлт, ач холбогдол, үр дүн	Авлигад өртсөн албан хаагчид байхгүй, иргэдийн санал гомдол ирээгүй. Албан хаагч болон иргэд авлига ашиг сонирлын зөрчлийн тухай тодорхой хэмжээний ойлголттой болсон.
9	Сум, байгууллагын төрийн албан хаагчдаас авлига, ашиг сонирхлын зөрчил гаргасан эсэх /тоо/	Байхгүй.
10	Авлигатай тэмцэх газраас авлига, ашиг сонирхлын зөрчил арилгах болон хариуцлага тооцохтой холбоотой ирүүлсэн албан бичиг, хариу өгсөн эсэх	Байхгүй.

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ

Б.ШАГДАРСҮРЭН
Н.ДАВААСҮРЭН

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГА

Б.БААСАН

